



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/07

Биндэр сум

Хүүхдийн эрх, олон нийтийн орчны аюулгүй
байдлыг хангаж, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх
хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5³.1 дэх заалт, Улсын онцгой комиссын 3 дугаар тушаал, Засгийн газрын 2022 оны 474 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”, Монгол улсын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгавар, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, албан байгууллагын дотор, гадна орчин, нийтийн эзэмшлийн зам талбай, хүүхдийн тоглоомын талбай, гэр хорооллын ойролцоох зам, гарц, гудамж авто машин болон иргэд олноор зорчдог хэсэг бүрд аливаа болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, таслан зогсоох, бууруулах үзлэг хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	М.Отгонбаяр	Засаг даргын орлогч
Гишүүд:	Б.Тунгалаг	Онон багийн Засаг дарга
	Б.Золбоо	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Н.Болор-Эрдэнэ	Байгаль хамгаалагч
	Т.Нарангарав	Байгаль хамгаалагч
	Б.Ханхүү	Хэсгийн төлөөлөгч

Нарийн бичгийн дарга: О.Ариунзаяа Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан

2.Хяналт шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 09-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 24-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж илэрсэн зөрчлийг фото зургаар баримтжуулан, илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН